60 жилийн түүхэн хөгжлийг тоймлох нь

(АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар АУС)

Х.Удвал[1], Ц.Сарантуяа[1], Ц.Даваачимэг[1], Б.Хостуяа[1], Д.Янсанжав[1], П.Батчимэг[2]

[1,2]АШУҮИС. Дорноговь АУС
Цахим шуудан: yansanjav@mnums.edu.mn, Утас: 96641252

Түлхүүр үг:

Дорноговь
ЭМШУИС
АУК
АУС

Товч утга: Эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүд, үе үеийн ахмадууд, төгсөгчид, шавь нар, зорилго нэгт хамт олнооров бахархан хойч үеийнхэндээ зориулан, он цагийн дараалал, түүхэн хөгжлийн үечлэлийн баримтат эх сурвалжид үндэслэн эмхэтгэж, энэхүү судалгааг хийсэн болно. **Зорилго**: АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургуулийн түүхэн хөгжлийг үечлэн тоймлох. **Арга, аргачлал:** Монгол улсын Засгийн газрын архив, Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газар (ЗДТГ)-ын Хууль эрх зүйн хэлтэс (ХЭЗХ)-ийн харъяа Төрийн архивын тасаг, Дорноговь аймгийн ИТХ-ын архив, АШУҮИС-ийн Захиргаа, хүний нөөцийн газар (ЗХНГ)-ын архив, сургуулийн архивын баримтууд, түүхт ойн ном, түүхийн баримт, дурсамж материалиудыг ашиглан судалгааг 2022 оны 06 сарын 20-ооc 2022 оны 09 сарын 10-ны хооронд хийж гүйцэтгэлээ. **Үр дүн:** АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь АУС нь 60 жилийн түүхийн хуудсанд: 1. Хүн эмнэлгийн техникум (1962-1991), 2. АУИС-ийн харъяа Анагаах Ухааны Коллеж (1992-2004), 3. АУИС-ийн харъяа Анагаах Ухааны Эрдэм Шинжилгээ–Сургалтын төв, 4. ЭМШУИС-ийн харъяа Дорноговь аймаг дахь Анагаах Ухааны Коллеж (2004-2010), 5. ЭМШУИС-ийн харъяа Дорноговь аймаг дахь салбар сургууль (2010-2013), 6. АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар АУС (2014 оноос) болтлоо анх захирал, орон тооны 8 багш[1], 12 ажилтан, 129 сурагчтай[2] үйл ажиллагаа нь эхэлж байсан бол өнөөдөр үндсэн багш 52, гэрээт багш 12, ажилтан, ажилчин-26, 600 гаруй оюутантай сургууль болон өргөжсөн байна. **Дүгнэлт:** АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургууль нь 60 жилийн түүхэндээ “Хүн эмнэлгийн техникум”-аас АШУҮИС-ийн салбар сургууль болтлоо 6 үе шатыг дамжин хөгжиж, бүс нутагтаа төдийгүй Монгол улсдаа “Дорноговийн Анагаах” нэрээр алдаршин, Алсын хараа, Эрхэм зорилгодоо хүрэх, үнэт зүйлээ тодорхойлсон, эрүүл мэндийн салбарт 8081 мэргэжилтнийг бэлтгэн гаргасан, уламжлал-шинэчлэлийг хослуулсан эрдмийн их уурхай болон хөгжсөн байна.

Үндэслэл: Монгол улсад “Дорноговийн Анагаах” нэрээр алдаршсан АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар АУС нь Бүгд Найрамдах Монгол Ард Улс (БНМАУ)-ын Сайд нарын Зөвлөлийн (СНЗ) 1962 оны 04 сарын 18-ний өдрийн 200-р тогтоолоор “Хүн эмнэлгийн техникум” нэртэй байгуулагдсанаас[3] хойш 60 жилийн түүхийг бүтээжээ. Тус сургууль нь АШУҮИС-ийн “Дэлхийн шилдэг 1000 их сургуулийн нэг болох” алсын хараан дор “Олон улсын стандартад нийцсэн орон нутаг дахь манлайлагч их сургууль байх” алсын хараа, “Олон улсын болон үндэсний эрэлт хэрэгцээнд нийцсэн эрдэм шинжилгээ, боловсрол, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэгдлийг хангасан орон нутаг дахь тэргүүлэх их сургууль болох” гэсэн эрхэм зорилгыг тавин ажиллаж байна.

Оюутан сурагчдыг нийгэмшүүлж, бусдын эрх чөлөөг хүндэтгэдэг, сурах хариуцлагаа бүрэн ухамсарласан, мэргэжилдээ дур сонирхолтой, бусдад чин сэтгэлээсээ туслах чин хүсэл эрмэлзлэлтэй мэргэжилтэн болгон бэлтгэх нь тус сургуулийн Монгол улсын эрүүл мэндийн салбар, анагаах ухааны хөгжилд оруулж байгаа хувь нэмэр юм.

Байгуулагдсан цагаасаа эмнэлгийн тусгай дунд мэргэжилтэн бэлтгэж байгаад 1992 оноос "Хүний их эмч", 1998 оноос бакалавр зэрэгтэй сувилагч, 2008 оноос бакалавр зэрэгтэй эх баригч (шаталсан) бэлтгэж эхэлсэн. 1995 оноос АНУ-ын Хятад эмнэлгийн товчоо (Chine medical board)-той хамтран "Анагаахын боловсрол", "Нийгмийн эрүүл мэнд" төсөл хэрэгжүүлж эхэлснээр сургалтын орчин, эрдмийн зэрэг цолтой багш нарын тоо эрс нэмэгдсэн[4]. 1998 онд "Оюутан түшиц" эмнэлгийг Браун төвд нээн ажиллуулж оюутан залууст эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж эхэлсэн ба 2015 онд эмнэлгийн зориулалттай 1950м^2 талбай бүхий "Мандах наран" түшиц эмнэлэгтэй болсноор[14] Дорноговь аймгийн ард иргэдэд нарийн мэргэжлийн эмчийн тусламж үйлчилгээ үзүүлэх боломжийг бий болгосон. Эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүд, ахмад багш, ажилтан, ажилчид, үе үеийн төгсөгчид, шавь нар, зорилго нэгт хамт олноороо бахархан хойч үеийнхэндээ зориулан, он цагийн дараалал, түүхэн хөгжлийн баримтат эх сурвалжид үндэслэн үечлэн эмхэтгэж, энэхүү судалгааг хийсэн болно.

Зорилго: АШУУИС-ийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургуулийн түүхэн хөгжлийг үечлэн тоймлох

Зорилт:

1. 60 жилийн түүхэн материал, эх сурвалжуудыг цуглуулах
2. 60 жилийн түүхэн материал, эх сурвалжуудад дүн шинжилгээ хийж тоймлон бичих

Арга, аргачлал: Монгол улсын Засгийн газрын архив, Дорноговь аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ийн харъяа Төрийн архивын тасаг, Дорноговь аймгийн ИТХ-ын архив, АШУУИС-ийн ЗХНГ-ын архив, АШУУИС-ийн Дорноговь аймаг дахь салбар АУС-ийн архивын материал, түүхийн баримт, дурсамж, материалиудыг ашиглан судалгааг 2022 оны 06 сарын 20-оос 2022 оны 09 сарын 10-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

Үр дүн:

1. Хүн эмнэлгийн техникум (1962-1991): БНМАУ-ын СНЗ-ийн 1962 оны 04-р сарын 18-ны өдрийн 200-р тогтоол (зураг 1)-ын дагуу "Хүн эмнэлгийн техникум" нэртэйгээр[3] анх байгуулагдан 09-р сарын 30-нд нээлтийн ёслолын цуглааныг Дорноговь аймгийн Соёлын ордонд хийж захирал, орон тооны 8 багш[1], 12 ажилтан[4], 5 ангийн 129 сурагчтайгаар[2] мөн оны 10-р сарын 04-өөс хичээллэж эхэлсэн[2]. Захирлаар Д.Жамъянжав, С.Даваадорж, Ч.Содном, Л.Одончимэд, Х.Цэрэндорж, Д.Нямхүү, хичээлийн эрхлэгчээр Ж.Санзайжамц, Ш.Маамаа, Б.Самдан, З.Батмөнх, М.Бадмааванчиг, Н.Мянгаа, Н.Балжинням, Д.Нямхүү, Д.Хорлоо, Д.Дуламжав, Т.Болдбаатар, С.Жадамба нар ажилласан[4].

Сургалт: 1970 оноос Эм найруулагч, 1972 оноос Сувилагчийн 2 жилийн курс, 1974 оноос Сувилагчийн дипломын анги, 1983 оноос Эх баригч бага эмч[4,5], 1989 оноос Бригадын бага эмч (2.5 жил)-ийн ангиудыг шинээр нээсэн.

Бүтэц: Заах аргын нэгдэл (ЗАН)-ийн ажлыг тогтмолжуулж, улмаар 1990 оноос багш нарыг мэргэжлийн чиглэлээр нь дөрвөн "ЗАН" болгон зохион байгуулж ажилласан. Үүнд:

1. Суурь мэдлэгийн ЗАН, эрхлэгч багш Д.Баатар
2. Мэргэжлийн суурь боловсролын ЗАН, эрхлэгч багш Х.Удвал
3. Сувилахуйн ЗАН, эрхлэгч багш Б.Далантай
4. Эмнэлзүйн ЗАН, эрхлэгч багш Б.Наранцэцэг

Бүтээн байгуулалт: Анхны хичээл Сайншанд өртөөний нутаг дэвсгэрт байрлах 251, 252 дугаар байр[3] (тухайн үеийн нэрээр Альбстрын заводын Хятад ажилчдын байр, Альбстрын хүмүүжих ажилчдын байр[6])-нд эхэлж байсан. (Зураг 2)

Дорноговь аймгийн Сайншанд өртөөний Альбстрын забодын 47102 төгрөг (тухайн үеийн ханш)-ийн барилга, эд хогшлыг Дорноговь аймгийн Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргааны 1962 оны 08 сарын 04-ний өдрийн 79 дүгээр тогтоолоор блансаас бланст шилжүүлснээр[7] манай сургуулийн үндэс суурь тавигдсан юм.

1969 онд Дорноговь аймгийн Барилга угсралтын контор 400 хүүхдийн суудалтай сургууль (одоогийн хичээлийн төв байр)-ийн байрыг барьж ашиглалтанд оруулав.

1967-1971 оны хооронд 200 оюутны дотуур байр, 400 хүний суудалтай клуб (одоогийн соёлын танхим), багш ажилчдын 22 айлын орон сууц. 120 хүний суудалтай гуанз, биеийн тамирын заал, хүнсний сэрүүн зоорь зэргийг өөрсдийн хүчээр барьж, багш, оюутны амьдрах, сурах нөхцлийг бүрдүүлэв[4].

1988 онд Сайншанд сумын II багт 260 хүүхдийн "Дотуур байр" шинэ (одоогийн Оюутны байр)-ээр ашиглалтанд орсон.

1991 онд 120 ортой Оюутны дотуур байр (одоогийн Офицерийн хойд талд байгаа оюутны 2-р байр, 2018 онд актлагдсан)-ыг өөрсдийн хүчээр засварлан тохижуулав.

Түүхэн амжилт: 1960-аад оны сүүлч 1970-аад оны эхэн үеэс эхлэн тус сургууль нь аймагтаа төдийгүй улсад сурлага, хүмүүжил, соёл – урлаг, спортын амжилтаараа манлайлж эхэлсэн юм. Үүнээс товч дурьдвал 1972 онд Монголын хувьсгалт залуучуудын эвлэл (МХЗЭ)-ийн төв хорооны "Тэргүүний ажилчин залуу" алтан медиаль, 1974 онд "Улсын тэргүүний сургууль", 1978 онд Оюутан сурагчдын хөдөлмөрийн гавшгай (ОСХГ) отрядын ажлаар улсад I байр, 1981 онд МАХН-ын Төв хороо, СНЗ, Монголын үйлдвэрчний эвлэл (МҮЭ), МХЗЭ-ийн төв хорооны "Гавшгайч хамт олон" медаль, 1982 онд "Социалист хөдөлмөрийн хамт олон", 1982 онд "Улсын тэргүүний соёлч сургууль", 1990 онд "Социалист хөдөлмөрийн аварга" сургууль болсон байна[4,8].

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын
Сайд нарын Зөвлөлийн

ТОГТООЛ

1962 оны 4 дүгээр сарын 18- ны өдөр | Дугаар 200 | Улаанбаатар хот

Хүн эмнэлгийн техникумыг шилжүүлэн байгуулах тухай.

Дорноговь,Дундговь,Өмнөговь,Сүхбаатар,Хэнтий зэрэг аймагт зориулан, хүн эмнэлгийн дунд мэргэжилтнийг бэлтгэх зорилгоор БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Улс ардын аж ахуй,соёлыг 1962 онд хөгжүүлэх төлөвлөгөөгөөр Архангай аймагт байгуулагдах хүн эмнэлгийн техникумыг Дорноговь аймгийн Сайншанд хотод шилжүүлэн байгуулсугай.

2.Сайншанд хот дахь хүн эмнэлгийн техникумын бүх бэлтгэл ажлыг хангаж, 1962/1968 оны хичээлийн жилээс нээж ажиллуулахыг Эрүүлийг Хамгаалах Яам /н.ТУВААН/-д даалгасугай.

3.Уул техникумыг ерөнхий боловсролын багш нараар энэ оны 8 дугаар сард багтаан хангахыг Гэгээрлийн Яам /н.ЖАМСРАН/-д даалгасугай.

4.Хүн эмнэлгийн техникумын орон байранд зориулан, Сайншанд өртөөний дэвсгэрт байгаа 251,252-р байшинг балансаас балансад шилжүүлж, тэдгээр байшинг аймгийнхаа барилгын ангиар энэ оны 8 дугаар сарын 1-ний дотор засварлуулж өгөхийг Дорноговь аймгийн ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа /н.САНЗАЖАВ/-т даалгасугай.

5.Архангай аймагт байгуулагдахаар төлөвлөгдсөн хүн эмнэлгийн техникумд зориулан батлагдсан төсөвт хөрөнгийг Дорноговь аймагт шилжүүлэхийг Сангийн Яам /н.ДҮГЭРСҮРЭН/-д даалгасугай.

6.Дорноговь аймгийн хүн эмнэлгийн техникумын орон байрыг засварлах,цахилгаан шугам шинээр татах зардалд шаардагдах хөрөнгийг төсвийн ёсоор гаргаж өгөхийг Улсын Төлөвлөгөөний Комисс /н.РАГЧАА/-д даалгасугай.

7.Сайд нарын Зөвлөлийн 1961 оны 148 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

Б Н М А Улсын Сайд нарын
Зөвлөлийн 1-р орлогч дарга МӨЛОМЖАМЦ

Б Н М А Улсын Сайд нарын
Зөвлөлийн Хэрэг Эрхлэх
газрын дарга БАЛДАРЧ

Хуулбар үнэн:Тогтоол анги
эрхлэгч /ЛАГВАДОРЖ /

Зураг 1. 1962 онд Дорноговь аймгийн Сайншанд өртөөнд Хүн Эмнэлгийн Техникум байгуулсан тогтоол



Зураг 2. Хүн Эмнэлэгийн Техникумын хичээлийн I байр (1962 он)

2. АУИС-ийн харъяа Анагаах Ухааны Коллеж (1992-1996, 1997-2004): Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 1991 оны 03-р сарын 28-ны өдрийн 124/А44 тоот тушаал, мөн Гэгээрлийн яам, Эрүүл мэнд нийгмийн хамгааллын яамны сайдын хамтарсан 1997 оны 05-р сарын 01-ний өдрийн А/176,120 тоот тушаалаар АУИС-ийн харъяа Анагаах Ухааны Коллеж болон өргөжин, захирлаар Д.Нямхүү, Эрдэм шинжилгээ, төгсөлтийн дараах сургалт (ЭШТДС) эрхэлсэн дэд захирал Д.Баатар, хичээлийн эрхлэгч, дэд захирлаар Т.Андрей, Д.Батбаяр, Б.Наранцэцэг, М.Отгончимэг нар ажилласан[4].

Сургалт: Шинээр бакалаврын сургалтын 2 хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн. Үүнд:

1. 1992 оноос Хүний их эмчийн анги (ангийн багш Ц.Амгалан, ангийн дарга Д.Атармаа, нийт 23 оюутан 1998 онд төгссөн)
2. 1998 оноос Сувилахуйн анги (ангийн багш Р.Уранчимэг Б.Далантай. ангийн дарга Л.Янжинсүрэн, нийт 40 оюутан 2002 онд төгссөн)

1992 оноос АУИС-ийн зочин профессорууд Б.Туяа, Ш.Жадамбаа, Л.Ажнай, Т.Гомбосүрэн, Ц.Сүхбаатар, Н.Мөнхцэцэг, Н.Цэдэв, Т.Зэвгээ, М.Мөнхзол, М.Онолбаатар, Б.Ганбаатар, Г.Батбаатар, С.Жамъяндавга, Б.Нацагдорж, Б.Баярсайхан нар уригдан ирж анагаахын ангид хичээл зааж эхэлсэн.

1995 онд Chine medical board-той хамтран хэрэгжүүлсэн “Анагаахын боловсрол”, “Нийгмийн эрүүл мэнд” төслийн үр дүнд багш нарын 20% доктор, 100% магистр, багш нарыг АНУ, Англи, Япон, ОХУ, Тайланд, Сингапур, Тайвань, Солонгос зэрэг улсуудад англи хэл болон мэргэжлийн чиглэлийн урт, богино сургалтуудад хамруулсан.

2000 онд Боловсролын магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг биелүүлэн анх удаа 5 жилээр магадлан итгэмжлэгдэв[4].

Бүтэц: 1995 оноос Тэнхимийн зохион байгуулалтанд шилжиж Суурь мэдлэг, Мэс засал–Эх барих, Анагаах ухаан, Нийгмийн эрүүл мэнд (НЭМ)-ийн тэнхим байгуулагдаж анхны эрхлэгчээр Д.Баатар, Х.Удвал, Б.Наранцэцэг, Ц.Амгалан, А.Таня. Б.Далантай, Ц.Сарантуяа, Ж.Энхтуяа нар ажилласан.

Бүтээн байгуулалт: 1995 онд АНУ-ын Хятад эмнэлгийн товчоо (Chine medical board)-той хамтран “Анагаахын боловсрол”, “Нийгмийн эрүүл мэнд” төслүүдийг хэрэгжүүлснээр Сувилахуйн ур чадварын симмулятор төв, Лингафоны утасгүй мультимедиа кабинет, 9 суваг бүхий кабелийн телевизийн төвийг байгуулав[4].

1998 онд Сайншанд сумын II багт өмнө нь Хүүхдийн эмнэлгийн зориулалтаар ашиглаж байсан барилгыг орон нутгийн өмчөөс шилжүүлэн 160 оюутны хичээлийн байр болгон тохижуулсан мөн онд “Браун” төвийг байгуулж “Оюутан түшиц” эмнэлгийн суурийг тавьсан. Уг эмнэлэг 2004 онд оюутны дотуур байрны 1 давхарт шилжин 8 чиглэлээр ард иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж эрхлэгчээр Б.Наранцэцэг Н.Будсүрэн, Х.Тогтуунбаяр, М.Нандинцэцэг, Б.Чимэдцэеэ, У.Энхбаяр, Д.Гүнжидмаа нар ажиллаж байв.

2000 онд Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутагт Аварга тосон амралтын газрыг түшиглэн сургуулийн “Говийн бүрд” амралт сувиллын газрыг байгууллаа[4].

Түүхэн үйл явдал: Манай төгсөгчдөөс 1996 онд Хэнтий аймгийн эх баригч Д.Дунгаамаа “МУ-ын гавъяат эмч”, 2000 онд сургуулийн захирал, АУ-ны доктор, дэд профессор Д.Нямхүү анхны “МУ-ын Гавъяат багш” цол хүртсэн нь бидний дундаас төрсөн анхны гавъяатууд юм[4].

3. АУИС-ийн харъяа Анагаах Ухааны Эрдэм Шинжилгээ–Сургалтын төв (1996-1997): Шинжлэх ухаан, Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайд,

Дорноговь аймгийн Засаг даргын хамтарсан 1996 оны 05-р сарын 03-ны өдрийн А/88,150/90 тоот тушаалаар Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй нэгтгэн АУИС-ийн харъяа Анагаах Ухааны Эрдэм Шинжилгээ–Сургалтын төв болон өөрчлөгдөн захирлаар Д.Нямхүү, ЭШТДС эрхэлсэн дэд захирал Д.Баатар, хичээлийн эрхлэгчээр Т.Андрей, Д.Батбаяр нар ажиллав[4].

1997 онд багш Д.Баатар Мал эмнэлгийн хүрээлэнгийн лабораторийн эрхлэгч, доктор Ц.Цэндсүрэнгийн удирдлага дор "Говийн ундны усны хатуулаг, химийн найрлага, агуулгыг хүн, малын бодисын солилцооны зарим үзүүлэлттэй харьцуулан судлах нь" сэдвээр биологийн ухааны магистрын зэрэг хамгаалснаар манай сургуулийн анхны магистр зэрэгтэй багш болсон юм.

4. ЭМШУИС-ийн харъяа Дорноговь аймаг дахь Анагаах Ухааны Коллеж (2004-2010): Гэгээрлийн яам, Эрүүл мэнд нийгмийн хамгааллын яамны сайдын хамтарсан 2003 оны 05 сарын 06-ы өдрийн А/176,120 тоот тушаалаар ЭМШУИС-ийн харъяа Анагаах Ухааны Коллеж болон нэр нь өөрчлөгдөн захирлаар Д.Нямхүү, ЭШТДС эрхэлсэн дэд захирал Д.Баатар, дэд захирал, сургалтын албаны даргаар М.Отгончимэг, Ж.Галбадрах, Ц.Сарантуяа нар ажилласан[4].

Сургалт: 2008 оноос шаталсан сургалттай Эх баригчийн анги (ангийн багш Б.Наранцэцэг, курсын дарга Б.Ариунаа, анхны 15 бакалавр мэргэжилтэн 2010 онд төгсөв) нээн элсэлт авч эхлэв.

2005 онд багш Ц.Сарантуяа ОХУ-ын Иркутскийн АУИС-ийн Микробиологийн институтэд Борисов В. А удирдлага дор "Клинико-эпидемиологическая характеристика бруцеллёза (по материалом Монголий)" сэдвээр докторын хөтөлбөрийг амжилттай дүүргэж сургуулийн анхны доктор төрсөн түүхтэй.

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2006 оны 05 дугаар сарын 26.-ны өдрийн хуралдаанаар 10 жилийн хугацаатай 2 дахь удаагаа магадлан итгэмжлэгдсэн. Unimis micro цахим мэдээллийн программыг 2005 оноос нэвтрүүлэн ажилласан бөгөөд энэ нь одоогийн Дээд боловсролын удирдлага мэдээллийн систем (www.xcloud.mn)-ийн суурь болсон юм.

Бүтээн байгуулалт: Норвегид төвтэй Laerdal medical-ын бүтээсэн өндөр технологи бүхий интерактив SIMMAN симуляторын иж бүрдлийг Монголд анх удаа оруулан ирж дэвшилтэт технологид суурилсан сургалтын сүүлийн үеийн арга болох виртуаль орчин, ур чадварт сургах энгийн симулятор, муляжуудтай эмнэл зүйн дууриамал орчныг бүрдүүлсэн кабинет байгуулав[9].

Түүхэн үйл явдал: 2007 онд тус сургуулийн захирал, АУ-ны доктор, дэд профессор Д.Нямхүүгийн Сувилахуйн боловсролд оруулсан хувь нэмрийг үнэлэн Тайланд улсын Гүнжийн нэрэмжит шагналаар шагнасан нь уг шагналыг хүртсэн Монголын анхны хүн болгов[9].

5. ЭМШУИС-ийн харъяа Дорноговь аймаг дахь салбар сургууль (2010-2013): БСШУЯ-ны сайдын 2010 оны 02 сарын 01-ний өдрийн №36 тоот тушаалын дагуу ЭМШУИС-ийн Дорноговь аймаг дахь салбар сургууль болов. Захирлаар Д.Нямхүү, Ц.Цабшир, сургалтын албаны даргаар Ц.Сарантуяа, Ю.Байгалмаа нар ажиллаж байсан[4].

Дорноговь аймаг дахь Анагаах ухааны коллеж нь Хүний их эмч, сувилахуй, эх барихуй чиглэлээр бакалавр, сувилагч, эх баригч, эм найруулагч, лабораторийн техникч, уламжлалт анагаахын бага эмч мэргэжлээр дипломын зэрэгтэй эмнэлгийн мэргэжилтнүүдийг бэлтгэж 1200 орчим оюутантай, 105 багш, ажилтан, ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж байв. Нийт багш нарын 53.3% нь гадаадад, 100% дотоодод мэргэжлээ дээшлүүлсэн байна.

Сургалт: Шинээр дипломын - 2 анги нээсэн. Үүнд:

1. 2011 оноос Лабораторийн техникчийн анги (ангийн багш Л.Янжинсүрэн, курсын дарга Т.Лхагвасүрэн, 2014 онд анхны 24 дүнд мэргэжилтэн төгсөв)
2. 2013 оноос Уламжлалтын бага эмчийн анги (ангийн багш Н.Ариунжаргал, курсын дарга Б.Соронзонболд, 2016 онд анхны 42 оюутан төгсөв). 2016 оноос Уламжлалтын сувилагч мэргэжилтэн бэлтгэж байна.

6. АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургууль (2014 оноос): Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулийн 24-р зүйлийн 24.2 дахь хэсэг[10], ЭМШУИС-ийн Удирдах зөвлөлийн 2014 оны 005-р тогтоол, ЭМШУИС-ийн 2014 оны 1/328 тоот албан бичгийг үндэслэн, Боловсролын сайдын 2014 оны 04-р сарын 09-ны өдрийн А/134 тоот тушаалаар Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургууль болон өргөжиж захирлаар Ц.Цабшир, М.Отгончимэг (одоог хүртэл) нар, Сургалтын албаны даргаар Ю.Байгалмаа, Д.Сансармаа, Б.Булгантуяа (одоог хүртэл) нар ажилласан.

Сургалт: Сургалтын үйл ажиллагаанд чанарын менежментийн тогтолцоог ISO 9001:2015 стандартын шаардлагын дагуу нэвтрүүлсэн тул 2018 оны 07 сарын 06-нд гэрчилгээ гардан авсанаар Дорноговь аймгийн хэмжээнд анхны олон улсын стандарт (ISO 9001:2015)-ыг хэрэгжүүлэгч байгууллага болсон[11].

2018 онд Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн удирдах зөвлөлийн 2018 оны 6 сарын 20 өдрийн 28 тоот тогтоолоор (гэрчилгээний №20181013) 3 дахь удаагаа амжилттай магадлан итгэмжлэгдэв[12].

Бүтэц: Шинээр чанарын удирдлагын хороо (АШУҮИС-ийн Дорноговь салбар сургуулийн захирлын 2017 оны 12 сарын 28-ны өдрийн А/158 тоот тушаал)[13], хөтөлбөрийн дэд хороо (АШУҮИС-ийн Дорноговь салбар сургуулийн захирлын 2022 оны 04 сарын 14-ний өдрийн А/29 тоот тушаал /шинэчлэсэн/)[14], эрдэмтэдийн зөвлөл (АШУҮИС-ийн захирлын 2022 оны 03 сарын 15-ны өдрийн А/58 тоот тушаал)-ийг тус тус байгуулав.

"Төгсөгчдийн холбоо" төрийн бус байгууллага 2019 онд байгуулж даргаар А.Дагвасүрэн,

Ю.Байгалмаа (одоог хүртэл) ажиллаж, 2022 оноос Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр, Хэнтий, Дорнод, Багануур дүүрэг, Налайх дүүрэг, Улаанбаатар хотод салбар зөвлөлүүдийг байгуулаад байна[14].

2021 онд Үйлдвэрчний Эвлэлийн Хорооны (ҮЭХ) тэргүүлэгчдийг шинэчлэн сонгож, сургуулийн захиргаа болон ҮЭХороо хоорондын "Хамтын гэрээ" (7 бүлэг, 62 заалт)-г байгуулан даргаар нь М.Долгор, Н.Мянгаа, Ж.Базаррагчаа, С.Жадамба, Ц.Тэрбиш, Б.Насанжаргал, Б.Мөнхцэцэг, А.Нямдаваа, М.Чинзориг, Дү.Батцэцэг (одоог хүртэл) нар ажиллаж байна.

Бүтээн байгуулалт: 2015 онд Дорноговь аймгийн нутгийн зөвлөлийн 4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Монгол улсад анх удаа их сургуулийн дэргэдэх эмнэлгийн байртай болсон. Уг эмнэлгийн байр нь зоорийн давхраа оруулаад нийт 4 давхар 1950м^2 талбайтай бөгөөд эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн №ЭХ-11/08/58 тоот гэрчилгээтэйгээр нийт 14 кабенит (мэс засал, гэмтэл, нүд, сэтгэл засал, мэдрэл, арьс харшил, дотор, хүүхэд, дүрс оношлогоо, БЗДХ, эмэгтэйчүүд, өдрийн эмчилгээ, физик эмчилгээ, уламжлалт, лаборатори)-аар ард иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэн, эмнэлгийн даргаар Д.Янсанжав, Б.Одончимэг (одоог хүртэл) ажиллаж байна[14].

2015 оны 09 сарын 14-нд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 829.4 сая төгрөгөөр 420 м^2 спорт заалтай болсон[14,15], 2017 онд өөрийн хөрөнгөөр хуучин спорт заалыг 2 давхар 100 суудал бүхий шинэ номын сан болгон шинэчлэв[16], 2020 оны 01 сард Төгсөгчдийн холбооны санхүүжилтээр "Цахим сургалтын төв" байгуулав.[14] Энэ оны 10 сард орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт (331.6 сая төгрөг)-аар оюутны дотуур байрыг бүрэн засварлав[14,17,18].

Түүхэн үйл явдал: Сургуулийнхаа 60 жилийн түүхийг бүтээлцсэн ахмад буурлуудаас АУ-ны доктор, кл.профессор, Эх барих эмэгтэйчүүдийн багш Б.Наранцэцэг 2022 онд анхны гавъяат багш цол хүртэв.

2022 онд тус сургууль нь 6 алба (Захиргаа, хяналт шинжилгээ, үнэлгээний алба, Сургалтын алба, Оюутны алба, Эрдэм шинжилгээ, мэдээлэл технологийн алба, Эмнэлгийн хөгжлийн алба, Санхүүгийн алба), орон тооны бус 2 зөвлөл (Захиргааны зөвлөл, эрдэмтэдийн зөвлөл), 2 хороо (чанарын хороо, хөтөлбөрийн дэд хороо) гэсэн шинэ бүтэцтэй ажиллаж байна.

Одоо бид хичээл сургалтыг нэг ээлжиндээ 560 оюутан хичээллэх боломжтой 2496 м^2 талбайтай хичээлийн 2 байр, 1950 м^2 талбай бүхий Мандах наран түшиц эмнэлэгт явуулахын зэрэгцээ 260 хүүхдийн дотуур байр, 17000 гаруй номын фондтой 100 хүүхдийн суудалтай 2 давхар номын сан, 420 м^2 талбайтай спорт заал, соёлын танхим, "Говийн бүрд" амралт сувиллын газар бүхий материаллаг орчинд сургалтын үйл ажиллагаагаа явуулж байна.

Хэлцэмж: Д.Баатар нарын эмхэтгэсэн сургуулийн 50 ойд зориулан гаргасан "Зүрхэнд оршдог, зүүдэн уяатай төрөлх сургууль минь" (2012), Ц.Түвшинтөгс нарын эмхэтгэсэн анхны төгсөгчдийн дурсамж ном "Мөнхөд дурсагдах сургууль минь" (2012), "Бидний эрт ба эдүгээ" (2016) номнууд бидний судалгааны суурь болсон.

Дээрх номнуудад 2012 он хүртэлх сургуулийн түүхэн хөгжлийн 5 үеийг тодорхойлсон бол бидний судалгаа дараагийн 6 дах үеийг харуулснаар түүхийн үргэлжлэл болж байна.

Дүгнэлт:

1. Монгол улсын Засгийн газрын архив, Дорноговь аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ийн харъяа Төрийн архивын тасаг, Дорноговь аймгийн ИТХ-ын архив, АШУҮИС-ийн ЗХНГ-ын архив, АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар АУС-ийн архивын материалууд – 32, түүхэн ном – 4 ашиглан тус сургуулийн түүхэн архивыг баяжуулав.
2. АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургууль нь 60 жилийн түүхэндээ "Хүн эмнэлгийн техникум"-аас АШУҮИС-ийн салбар сургууль болтлоо 6 үе шатыг дамжин хөгжиж, бүс нутагтаа төдийгүй Монгол улсдаа "Дорноговийн Анагаах" нэрээр алдаршин, Алсын хараа, Эрхэм зорилгодоо хүрэх, үнэт зүйлээ тодорхойлсон, эрүүл мэндийн салбарт 8081 мэргэжилтнийг бэлтгэн гаргасан, уламжлал - шинэчлэлийг хослуулсан эрдмийн их уурхай болон хөгжсөн байна.

Талархал: АШУҮИС-ийн Дорнорговь аймаг дахь салбар АУС-ийн 60 жилийн түүхийг тоймлоход тусалж дэмжсэн Монгол улсын Засгийн газрын архивын эрхлэгч Д.Батжаргал, Дорноговь аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ийн харъяа Төрийн архивын тасгийн дарга Ч.Чулуунцэцэг, ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлогын хэлтсийн дарга А.Амгаланзаяа, АШУҮИС-ийн ЗХНГ-ын архивын мэргэжилтэн Н.Эрдэнэсүрэн нарт гүн талархал илэрхийлье.

Ном зүй:

1. *Ялалт. Дорноговь аймгийн Намын хороо. Ардын депататуудын хурлын гүйцэтгэх захиргааны сонин. 1962 оны 10 дугаар сарын 4. №77 (1374).*
2. *Ц.Түвшинтөгс. Мөнхөд дурсагдах сургууль минь. УБ. 2012: 12-14*
3. *Монгол Улсын Засгийн газрын архив Х.1, Товьёг данс10, ХН-4, 21-22*
4. *Д.Баатар. Зүрхэнд оршдог, зүүдэн уяатай төрөлх сургууль минь. УБ. 2012: 8-11*
5. *Ц.Түвшинтөгс. Бидний эрт ба эдүгээ. УБ. 2016: 18-33*
6. *Дорноговь аймгийн Ардын Депутатуудыг Хурлын Гүйцэтгэх Захиргааны захирамж. Сайншанд. Дугаар 110. 1962.07.21 (ДГ аймаг. ЗДТГ. ХЭЗХ. Төрийн архивын тасаг)*
7. *Дорноговь аймаг. ЗДТГ. Хууль эрх зүйн хэлтсийн харъяа. Төрийн архивын тасаг. Х1, Т11, ХН74*
8. *Ялалт. Дорноговь аймгийн Намын хороо. Ардын депататуудын хурлын гүйцэтгэх захиргааны сонин. 1982. х5-10*
9. *Алтан хэлхээ 2019. УБ. 2019. 3-7*
10. *https://legalinfo.mn/mn/detail/344*
11. *АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар АУС-ийн архив.*

2018. Х№33. Б№5. ХН№180-185.
12. АШУУИС-ийн Дорноговь аймаг дахь салбар АУС-ийн архив. 2017. Х№33. Б№5. ХН№111-122 .
13. АШУУИС-ийн Дорноговь аймаг дахь салбар АУС-ийн архив. 2016-2017. Х№33. Б№5. ХН№101-110.
14. Менежрийн үр дүнгийн гэрээний тайлан (2015-2020)
15. АШУУИС-ийн Дорноговь аймаг дахь салбар АУС-ийн архив. Үндсэн хөрөнгийн тайлан. 2015. Х№33. х38.
16. АШУУИС-ийн Дорноговь аймаг дахь салбар АУС-ийн архив. Үндсэн хөрөнгийн тайлан. 2017. х1.
17. Дорноговь аймгийн ИТХ-ын архив. 2019. (2019 оны 12 сарын 04 өдрийн 12/09 дугаар тогтоолын 1 дүгээр хавсаралт)
18. АШУУИС-ийн Дорноговь аймаг дахь салбар АУС-ийн архив. Үндсэн хөрөнгийн бүртгэл 2020. Боть-2. УЖ:137. х84

To review 60 years of the historical development of the Dornogobi Medical School -a branch school of the Mongolian National University of Medical Sciences (MNUMS)

Udval Kh[1], Sarantuya Ts[1], Davaachimeg Ts[1], Khostuya B[1], Yansanjav D[1], Batchimeg P[2]

[1,2]Dornogobi Medical school, MNUMS
E-mail: yansanjav@mnums.edu.mn, Tel: +976-96641252


Background: This study was conducted based on chronological and historical development documentary sources with the pride of a community of healthcare professionals, seniors, graduates, and students, for future generations.
Aim: To periodically overview the historical development of the Dornogobi Medical School, MNUMS
Materials and Methods: Government Archives of Mongolia, Archive department of Legal Office of the Dornogobi Governmental Administration Office, Archive of Dornogobi Local Government Representative Office, Administration affairs, Human Resource affairs, and Archive department of the Mongolian National University of Medical Sciences, anniversary historical books, documents, and memorial materials were used in our study and the study was conducted from 29 August 2022 to 10 September 2022.
Results: The following information was included in the 60th - anniversary history of the Dornogobi Medical School: 1. Vocational school of medicine (1962-1991), 2. Medical College of Medical University (1992-2004), 3. Medical Research and training center of Medical University 4. Medical College of Health Science University (2004-2010), 5. Dornogobi Medical School –a branch school of the Health Science University (2010-2013), 6. Dornogobi Medical School –a branch school of the Mongolian National University of Medical Sciences (starting 2014). The Dornogobi Medical School started with 8 full-time faculty members, 12 workers, and 124 students while there are currently 52 full-time faculty members, 12 part-time teachers, 26 workers, and 600 students.
Conclusion: The Dornogobi Medical School – a branch school of the Mongolian National University of Medical Sciences has developed through 6 stages of history from the Vocational School of Medicine to The Dornogobi Medical School – a branch school of the Mongolian National University of Medical Sciences which defines its values for the mission, famous for ‘’Dornogobi Medical School’’ in not only region but also in Mongolia, trained 8081 health care professions and became a school which is a mining of academic education which combines traditional and modern approaches during past 60 years.

Keywords: Dornogobi, Health Science University of Mongolian, Medical College, School of Medical

ГРОПРИНОСИН®

Инозин пранобекс, шахмал болон сироп

ВИРҮСИЙН ЭСРЭГ ҮЙЛДЭЛТЭЙ ДАРХЛАЛ ДЭМЖИХ БЭЛДМЭЛ






Гедеон Рихтер

1901 оноос байгуулагдсан

АЭРТАЛ®

ацеклофенак

БҮХ ТӨРЛИЙН ӨВДӨЛТ, ҮРЭВСЭЛ БУУРУУЛАХ ЗОРИЛГООР ХЭРЭГЛЭНЭ





+



Аэртал 1.5% - 60гр крем

Аэртал 100мг шахмал

Үйлдэл:

- Өвдөлт намдаах
- Үрэвслийн эсрэг
- Хэсэг газрын хаванг бууруулах

Гедеон Рихтер

1901 онд байгуулагдсан